

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.8 дахь заалт, Компанийн Ногдол ашгийн бодлогын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг болон Компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 16.5 (арван зургаа аравны тав) төгрөгөөр тогтоож, 2025 оны цэвэр ашгийн 30.4 (гуч аравны дөрөв) хувийг буюу 12,198,477,769.5 (арван хоёр тэрбум нэг зуун ерэн найман сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун жаран ес аравны тав) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд байршуулж, Хувьцаа эзэмшигчдийн дансанд дамжуулан олгохоор шийдвэрлэсүгэй.
4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

